



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/11/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал.....	12
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/230
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянчандмань сум нь төрийн захиргааны байгууллагыг мэргэшсэн чадварлаг хариуцлага бүхий албан хаагчдаар бэхжүүлэн өндөр бүтээмжтэй ажиллан төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх эрхэм зорилготой байна.

"Тэрбум" мод хөдөлгөөний хүрээнд суманд "Соёл амралтын хүрээлэн"-гийн 2 га газрыг хашаажуулж хамгаалан шинээр ногоон байгууламж нэмэгдүүлж, нийт 2500 ширхэг мод бут тарьсан байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын 4,581,653.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 299,698.3 мянган төгрөгийн бараа материал, 107,902.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

GI/ArkhiV/Alban bichig 2023/ A4

19020301

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,234,492.70	1,070,732.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	300,655.00	457,272.20
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	476,326.80	454,964.50
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	457,510.90	158,495.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,966,781.80	1,544,267.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,966,781.80	1,544,267.40
39200	Биет хөрөнгө		5,585,950.10	1,410,984.80
39300	Биет бус хөрөнгө	13	380,831.70	133,282.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,201,274.40	2,614,999.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		27,469.70	9,848.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	27,469.70	9,848.50
41300	Өглөг	17а, 17б	27,469.70	9,848.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,173,804.70	2,605,150.90
51	Засгийн газрын хувь оролцоо		7,173,804.70	2,605,150.90
51100	Засгийн газрын оруулсан капитал		4,069,879.10	923,762.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		4,069,879.10	923,762.00
51200	Хуримтлагдсан үр дүн		1,574,368.20	1,491,030.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,529,557.40	190,358.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,201,274.40	2,614,999.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,182,535.30	1,969,029.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	222,798.40	932,108.40
110	Орлогын албан татвар	127,489.50	586,289.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	127,489.50	614,248.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-27,958.90
113	Хөрөнгийн албан татвар	12,690.00	113,390.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	82,618.90	232,429.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,110,672.00	738,145.30
120	Нийтлэг татварын бус орлого	1,110,672.00	738,145.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,849,064.80	298,775.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,908,460.60	1,564,359.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,908,460.60	1,354,977.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,773,000.30	1,294,616.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,496.60	300,930.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	250,159.60	37,742.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	316,468.10	326,502.20
2104	Хангамж, бараа материалын зардал	68,307.00	101,116.20
2105	Нормативт зардал	362,732.80	68,488.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,817.20	55,711.50
2107	Томилолт, зочны зардал	3,352.00	7,926.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,634.00	51,371.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	785,033.00	344,828.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,135,460.40	60,360.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	209,382.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	274,074.70	404,669.30
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	16.1	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	42,817.60	4,887,892.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	231,273.20	-4,483,223.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,604,425.90	1,735,112.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	222,798.40	932,108.40
110	Орлогын албан татвар	127,489.50	586,289.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	127,489.50	614,248.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-27,958.90
113	Хөрөнгийн албан татвар	12,690.00	113,390.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	82,618.90	232,429.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,838.80	25,161.80
1181	Газрын төлбөр	32,225.20	195,175.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,555.00	12,092.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	597,010.60	504,228.50
120	Нийтлэг татварын бус орлого	597,010.60	504,228.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,784,616.80	298,775.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,170,309.90	1,126,091.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,170,309.90	1,126,091.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,034,067.00	1,063,127.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,608.80	300,930.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	250,159.60	37,742.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,824.40	326,802.20
2104	Хангамж, бараа материалын зардал	140,683.00	65,986.70
2105	Нормативт зардал	68,406.10	74,874.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,762.70	56,611.50
2107	Томилолт, зочны зардал	3,352.00	7,926.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,541.60	51,340.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,728.70	140,913.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,136,243.00	62,964.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	434,116.00	609,020.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	126,868.90	217,724.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	126,868.90	217,724.70
2200	Дотоод эх үүсвэрээр	126,868.90	217,724.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-126,868.90	-217,724.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-166,000.00	-234,678.80
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	166,000.00	234,678.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	141,247.10	156,617.30
101	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	159,407.90	300,655.00
20	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,655.00	457,272.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,915,409.60	6,915,409.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,147.50	27,147.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,942,557.10	6,942,557.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-25.5	-25.5
9	Тайлант үеийн үр дүн	231,273.20	231,273.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,173,804.70	7,173,804.70
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,173,804.70	7,173,804.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,310,982.60	-1,310,982.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,862,822.10	5,862,822.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-13.3	-13.3
19	Тайлант үеийн үр дүн	-4,483,223.40	-4,483,223.40
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,605,150.90	2,605,150.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,720,361.9	1,417,340.0	303,021.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,062,696.0	969,096.2	93,599.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,017,809.1	925,964.2	91,844.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,249.7	300,930.2	36,319.5
210101	Үндсэн цалин	253,579.9	243,874.5	9,705.4
210102	Нэмэгдэл	67,347.6	51,972.0	15,375.6
210104	Урамшуулал	16,322.2	5,083.7	11,238.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,470.3	37,742.0	6,728.3
210201	Тэтгэврийн даатгал	30,980.3	25,962.3	5,018.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,372.6	3,054.4	318.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,697.9	2,433.4	264.5
210204	Ажилгүйдлийн даатгал	674.5	563.3	111.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6,745.0	5,728.6	1,016.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,886.4	326,802.2	32,084.2
210301	Гэрэл, цахилгаан	47,571.8	42,066.9	5,504.9
210302	Түлш, халаалт	305,957.6	283,596.3	22,361.3
210303	Цэвэр, бохир ус	5,357.0	1,139.0	4,218.0
2104	Хангамж, бараа материалын зардал	64,578.1	63,418.9	1,159.2
210401	Бичиг хэрэг	9,725.8	8,812.1	913.8
210402	Тээвэр, шатахуун	31,995.3	31,995.3	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,075.5	2,831.0	244.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	15,500.0	15,500.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,281.5	4,280.6	0.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,831.5	56,611.5	3,220.0
210604	Урсгал засвар	59,831.5	56,611.5	3,220.0
2107	Томилолт, зочны зардал	7,961.8	7,926.6	35.2
210702	Дотоод албан томилолт	7,961.8	7,926.6	35.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	52,041.3	50,657.0	1,384.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	48,988.0	48,944.6	43.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	748.0	748.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	311.1	247.0	64.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329.2	291.0	38.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165.0	22.0	143.0
210807	Газрын төлбөр	1,500.0	404.5	1,095.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,790.0	81,875.7	10,914.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,790.0	71,875.9	10,914.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000.0	9,999.8	0.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,886.9	43,132.0	1,754.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,886.9	43,132.0	1,754.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,986.9	30,986.9	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,900.0	12,145.1	1,754.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	383,665.9	213,565.0	170,100.9
221001	Их засвар	72,133.1	70,893.3	1,239.8
222001	Тоног төхөөрөмж	211,364.2	44,989.4	166,374.8
223001	Бусад хөрөнгө	100,168.6	97,682.2	2,486.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	274,000.0	234,678.9	39,321.2
230001	Эргэж төлөгдөх зээл	274,000.0	234,678.9	39,321.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,720,361.9	1,464,933.6	255,428.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	186,364.2	186,364.2	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	186,364.2	186,364.2	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,049,218.4	1,084,947.7	(35,729.3)
320001	Орон нутгийн төсвөөс	1,049,218.4	1,084,947.7	(35,729.3)
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	484,779.3	193,621.7	291,157.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	274,000.0	193,621.7	80,378.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	210,779.3	-	210,779.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	149,410.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	194,400.3	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	353,641.6	71,899.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,641.6	71,899.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,788.5	54,670.8
2104	Хангамж, бараа материалын зардал	8,955.9	2,388.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,481.2	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,209.5	400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		51,882.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,853.1	17,228.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,978.5	5,119.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,874.6	12,109.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	353,641.6	71,899.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,641.6	71,899.7
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Баянчандмань сум нь төрийн захиргааны байгууллагыг мэргэшсэн чадварлаг хариуцлага бүхий албан хаагчдаар бэхжүүлэн өндөр бүтээмжтэй ажиллан төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх эрхэм зорилготой байна.

“Тэрбум” мод хөдөлгөөний хүрээнд суманд “Соёл амралтын хүрээлэн”-гийн 2 га газрыг хашаажуулж хамгаалан шинээр ногоон байгууламж нэмэгдүүлж, намрын мод тарилтаар нийт 2500 ширхэг мод бут тарьж 8 аж ахуйн нэгж байгууллага, 180 иргэн оролцсон байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 57,900.0 мянган төгрөгийн спорт чийрэгжүүлэлт тоглоомын талбай тохижуулахад, шилжих үлдэгдлээс 34,500.0 мянган төгрөгийг цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоомын талбай тохижуулж, камержуулахад, 28,900.0 мянган төгрөгийг ЕБС-ийн биеийн тамирын талбайн тохижуулахад, 6,900.0 мянган төгрөгөөр эмнэлгийн бохирын хоолой солих, засварлах зэрэг бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, урианы жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийн ИТХТ-ээс гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд болон төсөвт байгууллагын бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээг хагас бүтэн жилээр хийж тайлагнасан байна.

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан “Батламж гэрээ”-ний хүрээнд хийсэн ажлын хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн 94,4%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянчандмань сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын засаг даргын А/212 дугаар захирамжийн дагуу сумын дотоод хяналтын баг төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл, тээвэр шатахуун, нөөцийн өвс тэжээл, төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод дотоод хяналт хийгдсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,586,275.0 мянган төгрөгөөр буюу 63,7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	300,655.0	457,272.2	156,617.2
Авлага	476,326.7	454,964.5	-21,362.2
Бараа материал	457,510.9	158,495.2	-299,015.7
Үндсэн хөрөнгө	5,966,781.8	1,544,267.5	-4,422,514.3
Нийт хөрөнгө	7,201,274.4	2,614,999.4	-4,586,275.0
Өр төлбөр	27,469.7	9,848.5	-17,621.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,173,804.7	2,605,150.9	-4,568,653.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,201,274.4	2,614,999.4	-4,586,275.0

Дээрх хүснэгтээс Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 457,272.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 156,617.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 253,539.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,511.7 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 165,212.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 88,650.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 454,964.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,362.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 74,039.2 мянган төгрөг, ЕБС-ийн 33,848.1 мянган төгрөг, Соёлын төвийн 15.1 мянган төгрөгийн, нийт 107,902.4 авлагыг шилжүүлсэн боловч, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 451,641.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 107,126.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 158,495.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 299,015.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг,

Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 299,698.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,544,267.5 мянган төгрөг болж, өмнөх оноос - 4,422,514.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,581,653.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,605,150.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,568,653.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 4,483,223.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 457,272.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 154,617.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	300,655.0	457,272.2	154,617.2
Төгрөг	300,655.0	457,272.2	154,617.2
Төрийн сангийн харилцах	299,437.6	447,939.6	148,502.0
Арилжааны банк дахь харилцах	1,217.4	9,332.6	8,115.2
Дүн	300,655.0	457,272.2	154,617.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 447,939.6 мянган төгрөгийн 56,6 хувь буюу 253,539.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 36,9 хувь буюу 165,212.8 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 6,5 хувь буюу 29,187.5 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байгаа өмнөх оноос 8,115.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 457,272.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 156,617.2 мянган төгрөгөөр өссөн нь газрын дуудлага худалдааны орлого 107,060.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих ковш худалдан авах тендерт оролцогч материал ирүүлээгүй тул 165,212.8 мянган төгрөгийг зарцуулаагүй зэргээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан нь э тайланд нүүр хуудас байхгүйгээс тус сангийн харилцах дансны 3,534.0 мянган төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн орлогын дансанд нэгтгэн тайлагнасан байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 454,964.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,362.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	55.4	44.3	-11.1
Зээлийн хүүгийн авлага	6,725.5	6,546.3	-179.2
Байгууллагаас авах авлага	172,651.1	32,765.3	-139,885.8
Хувь хүмүүсээс авах авлага	296,894.7	415,608.6	118,713.9
Дүн	476,326.7	454,964.5	-21,362.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 454,964.5 мянган төгрөгийн 91,3 хувийг хувь буюу 415,608.6 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,7 хувь буюу 414,278.2 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд Арж капитал компаниас төвлөрсөн 1,500.0 мянган төгрөгийн барьцааг бүртгэж тайлагнаагүй орхигдуулсныг аудитын явцад залруулсан.

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны оны эцсийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн 7,585.7 мянган төгрөгийг авлагаар тайлагнасныг залруулсан

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 158,495.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 299,015.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	91,240.8	66,556.0	-24,684.8
Тусгай зориулалттай материал	12,899.5	479.8	-12,419.7
Эм боох материал	78,341.3	66,076.2	-12,265.1
Хангамжийн материал	366,270.1	91,939.2	-274,330.9
Бичиг хэргийн материал	7,429.0	961.2	-6,467.8
Аж ахуйн материал	134,038.0	49,544.8	-84,493.2
Барилгын засварын материал	9,121.4	0	-9,121.4
Хүнсний материал	2,065.0	0	-2,065.0
Бусад хангамжийн материал	213,616.7	36,433.2	-177,183.5
Мал амьтад	0	5,000.0	5,000.0
Дүн	457,510.9	158,495.2	299,015.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 158,495.2 мянган төгрөгийн 57,8 хувийг ЗДТГ, 41,7 хувийг эмийн эргэлтийн сан, 0,5 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 299,015.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 152,087.9 мянган төгрөг, Цэцэрлэгийн 69,160.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 69,222.8 мянган төгрөг, Соёлын төвийн 9,227.1 мянган төгрөг, нийт 299,698.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нь үндсэн хөрөнгийн болон бараа материалын тайлангийн тодруулгаас 128,124.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг аудитын явцад залруулга хийгдсэн.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,991,440.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,075,443.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,684,633.7	2,856,514.5	-4,828,119.2

Барилга, байгууламж, орон сууц	5,248,641.9	807,880.7	-4,440,761.2
Авто-тээврийн хэрэгсэл	310,850.7	282,079.8	-28,770.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	672,570.0	334,333.7	-338,236.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	220,856.5	32,589.5	-188,267.0
Бусад үндсэн хөрөнгө	806,890.5	975,507.4	168,616.9
Дуусаагүй барилга, байгууламж Зам гүүр	409,123.4	424,123.4	15,000.0
Номын фонд	15,700.7		-15,700.7
Биет бус хөрөнгө	382,250.0	134,926.0	-247,324.0
Программ хангамж	59,554.0	2,040.0	-57,514.0
Бусад биет бус хөрөнгө	322,696.0	132,886.0	-189,810.0
Дүн	8,066,883.7	2,991,440.5	-5,075,443.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн 2,991,440.5 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,6 хувь буюу 2,981,365.3 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,1 хувь буюу 4,332.6 мянган төгрөгийг ИТХ, 0,2 хувь буюу 5,742.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5,075,443.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 2,794,812.6 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 1,156,405.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 525,347.3 мянган төгрөгийн, Соёлын төвийн 105,088.5 мянган төгрөгийн, нийт 4,581,653.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн өвс хаман боогч, үрлүүр болон бие чийрэгжүүлэлтийн танхимын дасгалын тоног төхөөрөмж нийт 290,282.1 мянган төгрөгийн буруу ангилан бүртгэснийг аудитын явцад залруулсан.
- Үндсэн хөрөнгө дансанд зам гүүрний барилга байгууламж дансанд зам засварын орлогыг 15,000.0 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө дансанд зам сайжруулалтыг 15,000.0 мянган төгрөгөөр гэх мэтээр ижил төрлийн хөрөнгийг өөр өөр дансанд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өгөгдсөн.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 29,112.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Засаг даргын нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгийн зардалд Орон нутгийн хөгжлийн сангийн 130,629.1 мянган төгрөг, ЗДТГ-ын 62,397.3 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг нэгтгэснийг залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9,848.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 17,647.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон өглөг	0	4.0	4.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,546.2	0	-7,546.2
Байгууллагад төлөх өглөг	19,395.8	9,316.8	-10,079.0
Хувь хүмүүст төлөх өглөг	527.7	527.7	0
Дүн	27,469.7	9,848.5	-17,621.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 17,621.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 25,902.8 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 9,848.5 мянган төгрөгийн үлдэгдлийн 7,633.4 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 1,500.0 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн, 511.7 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 203.4 мянган төгрөг нь Засаг даргын тамгын газрын өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 1,500.0 мянган төгрөгийн өглөгийг нэгтгээгүй орхигдуулсныг аудитын явцад залруулсан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,605,150.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,568,653.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,069,879.1	923,762.0	-3,146,117.1
Хуримтлагдсан үр дүн	1,574,368.2	1,491,030.3	-83,337.9
Өмнөх үеийн үр дүн	1,343,095.1	5,974,253.8	4,631,158.7
Тайлант үеийн үр дүн	231,273.1	-4,483,223.5	-4,253,950.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,529,557.4	190,358.6	-1,339,198.8
Дүн	7,173,804.7	2,605,150.9	-4,568,653.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4,568,653.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 3,146,117.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 1,339,198.8 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 4,631,158.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,253,950.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баянчандмань сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,946,000.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлыг 1,946,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баянчандмань сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,015,716.2 мянган төгрөгөөр, аймгийн санхүүгийн дэмжлэгийг 40,511.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 186,364.2 мянган төгрөгөөр, өмнөх оны шилжих үлдэгдлийг 130,110.7 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 250.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр 274,000.0 мянган төгрөгөөр, нийт эх үүсвэрийг 1,646,952.6 мянган төгрөгөөр, 2022 оны нийт зарлагын хэмжээг 1,646,952.6 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 7,009.3 мянган төгрөгөөр бууруулан 1,008,706.9 мянган төгрөгөөр, сумын 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,446,361.9 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 274,000.0 мянган төгрөгөөр, нийт 1,720,361.9 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 02 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,008,706.9 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 40,511.5 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 186,364.2 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 76,562.1 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 134,217.2 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 274,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 40,511.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,181,033.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 277,205.8 мянган төгрөг, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 186,364.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөө 110,6 хувиар буюу 106,538.5 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 8 нэр төрлийн орлого 16,5-86,2 хувиар тасарсан байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтэд газрын төлбөрийн орлого 220,5 хувиар буюу 89,173.3 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 448,9 хувиар буюу 45,358.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,417,339.9 мянган төгрөг буюу 82,3 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 36,319.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 32,084.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 1,159.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 3,220.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 35.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,384.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,914.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 1,755.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 170,101.0 мянган төгрөгөөр зардлуудыг хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, тогтмол зардлууд хэрэглээнээс шалтгаалан хэмнэгдсэн байна. Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 96,086.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	120,117.7	102,658.2	-17,459.5	85%
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	649,307.9	607,077.4	-42,230.5	93%
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	100,065.8	95,458.2	-4,607.6	95%
5	Ерөнхий боловсрол сургууль-тогтмол зардал	198,567.1	194,592.0	-3,975.1	97%
6	Эрүүл мэндийн төв- тогтмол зардал	37,841.8	32,661.4	-5,180.4	86%
7	Соёлын төв-тогтмол зардал	63,035.3	40,401.9	-22,633.4	63%
8	Хоршоо хөгжүүлэх сан-үндсэн үйл ажиллагааны зардал	274,000.0	234,678.8	-39,321.2	85%
9	Орон нутгийн хөгжлийн сан- хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	277,426.3	109,811.7	-167,614.6	39%
	Нийт	1,720,361.9	1,417,339.9	303,021.9	82.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 71,499.7 мянган төгрөг, ИТХ 400.0 мянган төгрөг, нийт 71,899.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01-2022.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 100%	120,117.7	102,658.2
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 107 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 93 %	649,307.9	607,077.4
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01-2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100%	274,000.0	234,678.8
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01-2022.12.31	Ерөнхий боловсролын сургууль нь 6 зорилт 17 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97 %	198,567.1	194,592.0
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01-2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 5 зорилт 26 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 95 %	100,065.8	95,458.2
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01-2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 30 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 63%	63,035.3	40,401.9
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01-2022.12.31		Хөтөлбөрийн хэрэгжилт 86%	37,841.8	32,661.4
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 3 төсөл, шинээр хэрэгжих 5 төслийг 277,426.3 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6, хэрэгжээгүй 1 хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 39%	277,426.3	109,811.7

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 01/82 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны урсгал үйл ажиллагааны зардал 1,446,361.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,694.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,271.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан ирүүлээгүй ба төсөвт байгууллагууд нь нийт 96,086.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаандаа байршуулсан төлөвтэй байна.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 26,290.3 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээ болон ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн 7 ажилтай холбоотой шийдвэр, гэрээ мэдээлэхээс 34,896.2 мянган төгрөгийн ажлын шийдвэр, гэрээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар гурван зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 01/228 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,262.0	1	2,262.0	100
Албан шаардлага	1	6,696.7	1	6,696.7	100
Зөвлөмж	3	76,527.9	3	76,527.9	100
Нийт дүн	3	85,486.6	3	85,486.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 199,526.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 199,526.4 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө болон бараа материалыг 5,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгийн зардалд Орон нутгийн хөгжлийн сангийн 130,629.1 мянган төгрөг, ЗДТГ-ын 62,397.3 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг нэгтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Байгалийн нөхөн сэргээх барьцаа санд төвлөрсөн барьцааны 1,500.0 мянган төгрөгийн өглөгийг нэгтгээгүй орхигдуулсан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 98,721.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 98,721.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 110,6 хувиар давж биелсэн боловч 8 нэр төрлийн орлого 16,5-86,2 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тодотгон батлагдсан дүнгээс 7,259.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 30,276.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст мэдэгдэн өөрчлөлтийг оруулж байх ба татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 26,290.3 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээ болон ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн 7 ажилтай холбоотой шийдвэр, гэрээ мэдээлэхээс 34,896.2 мянган төгрөгийн ажлын шийдвэр, гэрээг мэдээлэгдээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулааг үй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	199,526.4	1	1,500.0	2	198,026.4	3	199,526.4				
ЗДТГ	5	459,700.3			5	459,700.3	5	459,700.3				
Дүн	8	659,266.7	1	1,500.0	7	657,726.7	8	659,226.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Засаг дарга	2	37,535.3					2	37,535.3				
ЗДТГ	2	36,169.2	1	6,169.2			1	30,000.0				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга

Нийт зөрчил

Тоо

Дүн

Төлбөрийн акт

Тоо

Дүн

Албан шаардлага

Тоо

Дүн

Зөвлөмж

Тоо

Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

ЗДТГ

1

119,441.9

1

119,441.9

ОНХС

1

34,896.2

1

34,896.2

ЭЭС

1

26,290.3

1

26,290.3

Дүн

3

180,628.4

3

180,628.4

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил

Дүн

Нийт дүн

3

180,628.4

3

180,628.4

Зөрчлийн товч утга

Нийт зөрчил

Тоо

Дүн

Төлбөрийн акт

Тоо

Дүн

Албан шаардлага

Тоо

Дүн

Зөвлөмж

Тоо

Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

ЗДТГ

1

119,441.9

1

119,441.9

ОНХС

1

34,896.2

1

34,896.2

ЭЭС

1

26,290.3

1

26,290.3

Дүн

3

180,628.4

3

180,628.4

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил

Дүн

Нийт дүн

3

180,628.4

3

180,628.4